



БАБЕЗИОЗ

Цахим сонин №1

Халдвар хариуцсан баг


2015 он



Бабезиоз (Babesiosis B60.0, Пироплазмоз)

Бабезиоз нь хачгаар дамжиж, эгэл биетээр үүсгэгддэг, цусны улаан эсийг гэмтэсэнээс халуурах цус багадах, арьс салст шарлах зэрэг шинж тэмдгээр илэрдэг зоонозын хурц халдварт өвчин юм.

Бабезиоз өвчний үүсгэгч:



Babesia төрлийн 100 гаруй зүйлийн эгэл биетэн тэмдэглэгдсэнээс *B.divergens*, *B.microti*, *B.duncani*, *B.bovis*, *B.bigemina* зүйлүүд хүн болон сээр нуруутан түүний дотор хөхтөн амьтад, шувууг өвчлүүлдэг.

Зураг 1. *B.microti*,

Дамжуулагч:

Ixodidae овогт багтдаг бүх төрлийн хачгууд энэ өвчнийг дамжуулдаг боловч хүний өвчлөл үүсэхэд *Ixodes ricinus*, *Ixodes persulcatus* зүйлийн хачгууд зонхилдог.



Зураг 2. *Ixodes ricinus*




Халдварын эх уурхай:

Хөхтөн амьтан, жижиг мөргөгчид, үхэр, нохой, шувууд агуулагч амьтад болдог.

Халдвар дамжих зам:

Халдварын үүсгэгчийг агуулсан хачигт хазуулах буюу дам халдварын зам зонхилно. Эмнэл зүйн шинж тэмдэггүй өвчилсөн донорын цусыг хэрэглэх, өвчний үүсгэгчээр бохирдсон багажаар мээ ажилбар хийлгэх тохиолдолд халдвар дамжиж болно. Эхээс урагт дамжсан тохиолдол бүртгэгдсэн байна.




Зураг 3. Халдвар дамжих зам



Тархалт:

АНУ, Европ,
зүүн-омнод Азид
B.microti, Европын
улсууд Франц, Герман,
Ирланд, Серб
Монтенегро, Испани,
Швед, Их Британид
B.divergens бүртгэгддэг.



ОХУ-ын Урал, Ленинград муж, Сибирьт жижиг мэрэгчдийн 20, 2% нь *B.microti* зүйлээр халдварласныг тогтоосон байдаг.

Бабезиозын хүний өвчлөлийн анхны тохиолдлыг өнгөрсөн зууны 50 –над оны үед Европд оношлож эхэлсэн (үүсгэгч нь *B.divergens*). Нилээд хожим 60-аад оны сүүлчээр *B.microti* зүйлээр сэдээгдсэн өвчлөлийг АНУ-д илрүүлсэн байна. Одоогоор Америк, Ази, Африк тивийн бусад улсуудад энэ халдвар бүртгэгдээд байна.

Монгол орны газарзүйн янз бүрийн бүсээс цуглуулсан адууны цусны шинжилгээгээр 72.8% нь *B.equii*, *B.caballi* зүйлээр халдварласан болохыг мал эмнэлгийн судлаачид тогтоосон байна.

Эмнэлзүй: Хачигт хазуулсны дараах цөөн хоногт эмнэлзүйн шинж тэмдэг илэрч болнов Нууц үеийн хугацаа 1-3 долоо хоног, өвчний явцын хүндрэлээс шалтгаалан 3 хэлбэрийн шинж тэмдэг тохиолддог. Үүнд

- 1) Далд шинж тэмдэг: хазуулсанаас хойш хэдэн хоногийн дараа эхлэх бөгөөд нэг сараас жилийн хугацаанд үргэлжилдэг. Энэхүү тохиолдолд өвчтөн гэнэт хүндрэх, мөн өөрөө эх уурхай болж, халдварыг бусдад дамжуулах аюултай байдаг.



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Цахим сонин №1

- 2) Дунд явцтай буюу вирусын халдварт өвчинтэй төстэй шинж тэмдэг: халуурах (38-40 хэм), ядрах, даарах, хөлрөх, толгой өвдөх, булчин өвдөх, хоолонд дургүй болох, ханиах (томуу тест), үе мөч өвдөх, дотор муухайрах зэрэг хордлогын шинж тэмдэг илэрнэ.
- 3) Хүнд явцтай буюу нас баралтад хүргэх шинж тэмдэг: Халууралт 40-41 хэм хүрэх, амьсгалын цочмог дутагдал, судсан доторх түгмэл бүлэгнэлт, зүрхний дутагдал, элэг бөөрний дутагдлаар хүндэрнэ.

Өвчний нийтлэг шинж тэмдэг:

- Халуурах
- Бие жижүүцэх
- Булчин өвдөх, сульдах, ядрах
- Цус багадалттай хавсарсан шар өвчний шинжүүд илэрдэг
- Хэд хоногоос хэдэн сараар илэрнэ

Эмчилгээний зарчим

Шинж тэмдэг илэрсэн өвчтөнүүдэд наад зах нь 7-10 хоногийн хугацаанд хавсарсан эмчилгээ шаарддаг. Эмийн торлоос шалтгаалан эмчилгээг 2 хэлбэрээр хийдэг. Зарим өвчтөн хүндэрсэн үед дэмжих зорилгоор диализ, механик вентилиаци, судасны даралт тогтворжуулах зэрэг эмчилгээг хавсарч хийдэг.



Урьдчилан сэргийлэлт:



- Эрдэлээс сэргийлэх энгийн арга болох тод өнгийн, битүү хувиас, малгай өмсөх, өөртөө болон бусдад ялангуяа бага насны хүүхдүүдэд хачиг ассан эсэхийг ойр ойрхон шалгах замаар хараа хяналтаа сайжруулах;




- Хувиас эсвэл биед наалдсан, шигдсэн хачгийг салгаж авах аргад суралцах, салгасан хачгийг мэргэжлийн байгууллагад хүргэх;



- Хачигт хазуулсан, ямар нэг зовиур, эмнэл зүйн шинж илэрсэн тохиолдолд эмч, эмнэлгийн байгууллагад яаралтай хандаж, оношилгоо, эмчилгээ хийлгэхийн ач холбогдол;

- Хачигтай байж болзошгүй арьс шир, ноос ноолуурыг гэр орондоо байрлуулах, хадгалахаас аль болохоор татгалзах, хүүхдээс хол байлгах



- Хачиг дайжуулагч бодисыг сонгон хэрэглэх



Эх сурвалж:

- <http://www.mongolmed.mn/article/2520> (Д.Абмэд, Д.Ану, Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүд, 2012, 1(44))
- Видео <https://www.youtube.com/watch?v=JOakhoorjoQ>
- Source of video:http://www.tickencounter.org/prevention/human_babesiosis
- <http://www.cdc.gov/parasites/babesiosis/surveillance.html>
- http://www.cdc.gov/parasites/babesiosis/health_professionals/index.html#tx
- <http://www.emedmd.com/content/babesiosis>
- <http://mygermanshepherd.org/periodical/how-to-get-rid-of-ticks/>

Уг өвчинтэй холбоотой шинж тэмдэг илэрсэн
тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай
хандах

Халдвар хариуцсан баг